

**ХААН банкнаас мэдээлэв**



25 сая ам долларын санхүүжилт ХААН Банкны харилцагчдад хүрэхээр боллоо

ХААН Банк, Европын Сэргээн Босголт, Хогжлийн Банк /ЕСБХБ/-тай хамтран нэмүү ортгийн сүлжээ, бичил жижиг, дунд бизнесийг дэмжих санхүүжилтийн гэрээнд гарын үсэг зурлаа. Гарын үсэг зурах ёслолд ХААН Банкны ТУЗ-ийн гишүүн Ц.Баатарсайхан, Д.Хулан болон Гүйцэтгэх захирал Норихико Като, ЕСБХБ-ны ерөнхийлогч Сума Чакрабарти, Турк, Зүүн Омнод Европ, Тов Ази хариуцсан захирал Оливье Декамп болон бусад албаны хүмүүс оролцлоо.

Энэхүү 25 сая ам долларын гэрээг үзэглэснээр нэмүү ортогийн сүлжээг дэмжих цоо шинэ санхүүгийн хэрэгслийг Монголд нэвтрүүлж байгаа тодийгвй бичил жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан санхүүжилтийн хүртээмжийг сайжруулах юм.

ХААН Банкны хувьд жижиг дунд бизнесийг дэмжих чиглэлээр олон шинэ санаачлага хэрэгжүүлж ажилладаг. Тухайлбал байгуулагуудтай хамтран бvх торлийн зээл, тослийн зээлийг олгодгоос гадна тусгайлсан бизнес товvдээр дамжуулан ЖДБ эрхлэгчдэд банкны цогц вйлчилгээг хүргэдэг бол бизнес инкубатор тов нь ЖДБ эрхлэгчдийг бvх торлийн зовлогоо сургалтанд vнэ толборгvй хамруулдаг.

ЕСБХБ, ХААН Банкны бас нэгэн хамтын ажиллагааны дvнд Монгол улсын жижиг дунд

бизнес эрхлэгчдэд хүрэх санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх таатай ноцол бүрдсэн тодийгвй бичил бизнес эрхлэгчид болон нэмүү ортгийн сүлжээ буюу бэлтгэн нийлүүлэгчдэд зориулсан санхүүгийн нэгэн шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүлээ.

Гэрээг үзэглэх арга хэмжээний үеэр ЕСБХБ-ны Ерөнхийлогч ноён Сума Чакрабарти хэлэхдээ: “Монгол дахь манай сайн тvншvүдийн нэг ХААН Банктай хамтран нэмүү ортгийн сүлжээг санхүүжvүлэх шинэлэг бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрvүлж байгаадаа баяртай байна. ЕСБХБ-ны Монгол улсад явуулах вйл ажиллагааны тэргvүлэх чиглэлийн нэг нь байгалийн нооцийг эдийн засгийн эргэлтэнд оруулснаар бий болох ондор осолтоос эдийн засаг тогтвортой vр огоож хүртэхэд дэмжиж туслах юм. Энэхүү санхүүжилтийн шинэ хэрэгсэл нь ходоо аж ахуй, жижиглэн худалдааны салбарт вйл ажиллагаа явуулж буй БЖДБ-вүдээс гадна томоохон уул уурхайн компаниудын ханган нийлvүлэгчдэд хүрэх юм” хэмээлээ.

Харин ХААН Банкны Гvйцэтгэх захирал Норихико Като хэлэхдээ:

“Манай банк ЕСБХБ-тай хамтран томоохон компаниудын ханган нийлvүлэгчээр ажилладаг бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд хүрэх санхүүжилтийн хүртээмж, хэмжээг нэмэгдvүлэхийг зорьж байна. Энэ хамтын ажиллагааны хүрээнд ханган нийлvүлэгч, тvгээгчид болон томоохон компаниудын хооронд нэмүү ортгийн сүлжээг vүсгэж, харилцан холбоог дэмжих юм. Ингэснээр ортгийн сүлжээ бүхэлдээ бэхжинэ гэж vзэж байна. ЕСБХБ-наас олгож байгаа зээлийн тусламжтайгаар бичил жижиг дунд бизнес эрхлэгч манай харилцагчдад очих санхүүжилтийн хэмжээг нэмэгдvүлэх боломж бүрдсэнд баяртай байгаа онцлон тэмдэглэсэн юм.

ЕСБХБ нь Монгол улсын эдийн засгийн олон салбарт 1 тэрбум гаруй ам. долларын хоронго оруулалт хийж, Монгол оронд баримтлах стратеги бодлогоо саяхан шинэчлэн баталсан. Энэхүү стратегийн дагуу эдийн засгийн торолжилт, тогтвортой хөгжилд онцгой анхаарал хандуулж байгаа бөгөөд бичил жижиг дунд бизнесийг дэмжих нь зорилтын нэг хэсэг юм.

